

**“ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ”-ЫН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН
ТӨСӨЛ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлох, бүртгэлжүүлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Тайлбар: “үнэт металл” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт заасныг, “үнэт чулуу” гэж Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь хэсэгт тус тус заасныг ойлгоно.

1.2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч этгээд (цаашид “арилжаа эрхлэгч этгээд” гэх) нь тусгай зөвшөөрлийн хүрээнд дараах төрлийн үйлчилгээг эрхэлнэ:

1.2.1. үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх;

1.2.2. үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх.

1.3. Дээр дурдсан үйл ажиллагааг энэ журамд заасан тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээд эрхэлнэ.

**Хоёр. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа
эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдэд тавигдах нөхцөл, шаардлага**

2.1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь энэ журмын 1 дүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 4 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

2.1.1. компанийн тухай хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байх;

2.1.2. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангасан байх;

2.1.2.a. суманд үйл ажиллагаа эрхлэх бол 3,000,000 (гурван сая) төгрөг;

2.1.2.b. аймагт үйл ажиллагаа эрхлэх бол 5,000,000 (таван сая) төгрөг;

2.1.2.c. нийслэлд үйл ажиллагаа эрхлэх бол 10,000,000 (арван сая) төгрөг.

2.1.3. хувь нийлүүлсэн хөрөнгийг мөнгөн хөрөнгөөр бүрдүүлэх бөгөөд зээлийн эх үүсвэрээр бүрдүүлээгүй, хууль ёсны орлого байх;

2.1.4. үйл ажиллагаа явуулах ажлын байр, зориулалтын тоног төхөөрөмжтэй байх;

2.1.5. хоёроос доошгүй ажилтантай байх (гэрээт болон орон тооны бус ажилтан байж болно);

2.1.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон байх (Компанийн тухай хуулийн 83.5);

2.1.7. эрхлэх үйл ажиллагааг зохицуулсан дотоод журам, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөртэй байх;

2.1.8. үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь 3 жилийн бизнес төлөвлөгөө боловсруулан баталсан байх;

2.1.9. эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

2.1.10. Хорооноос зохион байгуулсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр сертификатжуулсан сургалтад холбогдох албан тушаалтан нь хамрагдсан байх

Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Холбооноос зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, сертификат авсан байх;

2.1.11. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад баримт бичиг.

Гурав. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх хувь хүнд тавигдах нөхцөл, шаардлага

3.1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх хувь хүн нь энэ журмын 1 дүгээр хавсралтын дагуу өргөдөл гаргаж, 5 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байх бөгөөд дараах нөхцөл, шаардлагыг хангасан байна:

3.1.1. үйл ажиллагаа явуулах ажлын байр, зориулалтын тоног төхөөрөмжтэй байх;

3.1.2. Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

3.1.3. Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу Холбооноос зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, сертификат авсан байх;

3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь дараах нийтлэг шаардлагыг хангаж ажиллана:

3.2.1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай, Зөвшөөрлийн тухай, Компанийн тухай, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, Хорооноос баталсан журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана;

3.2.2. арилжаа эрхлэгч этгээд нь 20 сая төгрөг болон түүнээс дээш бэлэн мөнгөний гүйлгээ хийх тохиолдолд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад зааснаар Мэдээлэх үүрэгтэй этгээдэд тооцогдоно;

3.2.3. мэдээлэх үүрэгтэй этгээдэд тооцогдсон арилжаа эрхлэгч этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан үүргийг хэрэгжүүлнэ;

3.2.4. хэрэв хуулийн этгээдийн дүрэмд 20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээг хийхгүй байх талаар зохицуулалт тусгагдсан бол энэ журмын 3.2.2 дахь заалт хамаарахгүй;

3.2.5. Хорооноос баталсан журмын дагуу жил бүр болон тухай бүр төвлөрүүлэх зохицуулалтын үйлчилгээний хөлсийг тогтоосон хэмжээгээр журамд заасан хугацаанд төвлөрүүлэх;

3.2.6. Хорооноос баталсан холбогдох журмын дагуу харилцагчийн талаарх бүртгэлийг хөтөлдөг байх;

3.2.7. Хорооноос тавигдах шаардлага, шалгуурыг хангаж ажиллах;

3.2.8. холбогдох хууль тогтоомжийн дагуу Хорооны хяналт, шалгалтад хамрагдах;

3.2.9. худалдах үнэт металл, үнэт чулуу, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийг сорьцын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаар сорьц тогтоолгон баталгаажуулсан байх.

3.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч этгээд нь хувь хүн бол энэ журмын 3.1, 3.2.1-3.2.3, 3.2.5-3.2.9-д заасан шаардлагыг тогтмол хангаж ажиллана.

Дөрөв. Тусгай зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

4.1. Тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, баримт бичгийг Хорооны бичиг хэргийн ажилтан хүлээн авч, энэ тухай бүртгэлд тусган, холбогдох ажилтанд шилжүүлнэ.

4.2. Хорооны холбогдох ажилтан тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, баримт бичгийг хүлээн авснаас хойш Зөвшөөрлийн тухай хуулийн 2 болон 3-т заасан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

4.3. Тусгай зөвшөөрөл хүсэгч холбогдох нөхцөл, шаардлагыг хангаж буй эсэхийг Хорооны холбогдох ажилтан ажлын 10 өдрийн дотор магадлан шалгах бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацааг нэг удаа ажлын таван өдрөөр сунгаж болно.

4.4. Тусгай зөвшөөрөл хүсэгчийн өргөдөл, түүнд хавсаргасан баримт бичиг нь шаардлага хангаагүй, эсхүл бүрдэл дутуу бол нөхөн бүрдүүлэх хугацаа 30 хүртэл хоног байх бөгөөд тус хугацаанд баримт бичгийг нөхөн бүрдүүлж ирүүлээгүй бол өргөдөл гаргаагүйд тооцно.

4.5. Энэ журмын 1.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар холбогдох хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ.

4.6. Хороо тусгай зөвшөөрлийг хугацаагүйгээр олгох бөгөөд тус шийдвэрт эрхлэх үйлчилгээний төрлийг тодорхой тусгана.

4.7. Тусгай зөвшөөрөл олгосон тухай шийдвэрийг үндэслэн Хороо тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгож, нэгдсэн бүртгэлд бүртгэн, зохих зааврын дагуу хувийн хэрэг нээн хөтөлнө.

4.8. Энэ журмын 4.5-д заасан Хорооны шийдвэрийг үндэслэн арилжаа эрхлэгч этгээд нь Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлснээр үйл ажиллагаа эхлүүлсэнд тооцно.

4.9. Тусгай зөвшөөрөл олгогдсонтой холбоотой өөрчлөлтийг энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээний болон дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

4.10. Хороо дараах үндэслэлээр тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

4.10.1. хуулийн этгээд бол энэ журмын 2.1, хувь хүн бол 3.1-т заасан шаардлагыг хангаагүй;

4.10.2. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн болох нь тогтоогдсон;

4.10.3. холбогдох хууль тогтоомж болон энэ журамд заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй;

4.10.4. тусгай зөвшөөрөл хүсэж ирүүлсэн баримт бичгийг хууль тогтоомжийн шаардлагад нийцэхүйц хэмжээнд бүрдүүлэх хугацаа 30 хоног бөгөөд тус хугацаа өнгөрсөн;

4.10.5. хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн эх үүсвэрээр бүрдүүлсэн эсхүл мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдоогүй, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй;

4.10.6. хууль тогтоомжид заасан бусад нөхцөл, шаардлагыг хангаагүй.

4.11. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.12. Хороо зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд тухайн өргөдөл гаргагч этгээдээс тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг 6 сарын дотор дахин хүлээн авахгүй.

4.13. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

Тав. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой бүртгэл

5.1. Тусгай зөвшөөрөлтэй этгээд нь дараах өөрчлөлтүүдийг оруулахын өмнө тухай бүр Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ:

5.1.1. хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах;

5.1.2. салбар, төлөөлөгчийн газар нээх;

5.1.3. оноосон нэр өөрчлөх;

5.1.4. ажиллагаа эрхлэгч хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөх;

5.1.5. үйл ажиллагаа эрхлэх хаяг өөрчлөгдөх.

5.1.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан өөрчлөгдөх.

5.2. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахад энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 7 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлсэн байна.

5.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд дараах хэлбэрээр өөрчлөлт оруулж болно. Үүнд:

5.3.1. хувьцаа эзэмшигчдийн мөнгөн хөрөнгөөр;

5.3.2. үндсэн үйл ажиллагааны хуримтлагдсан ашгаас хуваарилсан ногдол ашгаар нэмж хөрөнгө оруулах;

5.3.3. хувьцаа нэмж гаргах;

5.3.4. хувьцаа эзэмшигчээс оруулсан хувьцааг Иргэний хуульд заасны дагуу өвлүүлэх, бэлэглэх, өөр хоорондоо болон гуравдагч этгээдэд худалдах;

5.3.5. Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг хангах боломжтой, санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, хохирол учруулахгүй бол хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хорогдуулах.

5.4. Энэ журмын 5.3-т заасан өөрчлөлтийг тухай бүр Хороонд бүртгүүлэх бөгөөд өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

5.4.1. хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.4.2. хувьцаа эзэмшигч өөрчлөгдөж байгаа бол шинээр томилогдсон хувьцаа эзэмшигч нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

5.4.3. арилжаа эрхлэгч этгээдийн хувьцааг худалдан авч буй хувьцаа эзэмшигчийн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн байх;

5.5. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхтэй холбоотойгоор мөнгөн хөрөнгийг хууль ёсны үйл ажиллагаанаас олсон болох нь нотлогдохгүй, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ хэлцэл нь хуурамч тохиолдолд бүртгэхээс татгалзана.

5.6. Энэ журмын 5.5-д заасны дагуу бүртгэхээс татгалзсан тохиолдолд энэ талаар хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

5.7. Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 9 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлж, тухай бүр бүртгүүлэх бөгөөд бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

5.7.1. үйл ажиллагаа явуулах нутаг дэвсгэрийн хязгаарлалтыг тодорхойлсон, хаяг байршил нь тодорхой, байнгын ажлын байр, тоног төхөөрөмжтэй байх;

5.7.2. салбар, төлөөлөгчийн газрын удирдлагаар ажиллах этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх;

5.7.3. салбар, төлөөлөгчийн газрын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх;

5.8. Арилжаа эрхлэгч хуулийн этгээд нь оноосон нэр өөрчлөх тохиолдолд энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 10 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлж, тухай бүр өөрчлөлтийг бүртгүүлэх бөгөөд оноосон нэр нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхээргүй байна.

5.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг холбогдох ажилтан хянаж, зөвлөгөө өгөх бөгөөд тухайн өргөдөл, баримт бичгийг бичгийн бүрдүүлбэр, шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны бичиг хэрэгт бүртгүүлнэ.

5.10. Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн шинэчилсэн буюу өөрчлөлт оруулсан дүрмийн хуулбарыг Хороонд ирүүлнэ.

5.11. Салбар, төлөөлөгчийн газрыг дараах үндэслэлээр бүртгэлээс хасаж, нийтэд мэдээлнэ:

5.11.1. салбар, төлөөлөгчийн газар татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;

5.11.2. холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг удаа дараа биелүүлээгүй болон салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх нь тогтоогдсон;

5.11.3. Хорооноос тогтоосон нөхцөл, шаардлагыг хангаагүй;

5.11.4. хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

5.12. Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулах бөгөөд тусгай зөвшөөрөл эзэмшигчид салбар, төлөөлөгчийн газрын гэрчилгээг олгоно.

5.13. Эрх бүхий албан тушаалтан өөрчлөгдөн томилогдох тухай бүр энэ журмын 4 дүгээр хавсралт дахь маягтын дагуу өргөдөл гаргаж, 7 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд ирүүлэх бөгөөд уг өөрчлөлтийг бүртгүүлэхэд дараах шаардлага тавигдана:

5.13.1. шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын удирдлага нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан байх.

5.14. Энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй эсхүл хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд арилжаа эрхлэх этгээдийн эрх бүхий албан тушаалтан, салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлтийг Хороо бүртгэхээс татгалзана.

5.15. Эрх бүхий албан тушаалтан болон салбар, төлөөлөгчийн газрын удирдлагын өөрчлөлтийг бүртгүүлэх хүсэлтийн дагуу бүртгэл хийж, хариуг албан бичгээр мэдэгдэнэ.

5.16. Албан ёсны хаяг болон салбар, төлөөлөгчийн газрын хаяг өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 10 өдрийн дотор энэ журмын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу өргөдөл гаргаж, 11 дүгээр хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд албан бичгээр ирүүлж, бүртгүүлнэ.

5.17. Хаягийн өөрчлөлтийг бүртгэсэн бол тухайн зохицуулалттай этгээдийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад холбогдох тэмдэглэгээг хийнэ.

5.18. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан өөрчлөгдөх тохиолдолд журмын 4 дүгээр хавсралтаар батлагдсан маягтын дагуу өргөдөл гаргаж, 12 дугаар хавсралтад заасан баримт бичгийг үнэн зөв, бүрэн гүйцэд бүрдүүлэн Хороонд албан бичгээр ирүүлж, бүртгүүлнэ.

5.19. Энэ журмын 5.1.1-5.1.6-д заасны дагуу бүртгүүлэхээр ирүүлсэн хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногийн дотор хянаж, өөрчлөлтийг бүртгэх ба шаардлагатай тохиолдолд хугацааг ажлын 10 хоногоор сунгаж болно.

5.20. Энэ журмын 5.19-д заасны дагуу Хороонд бүртгүүлж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад зохих тэмдэглэгээг хийж, баталгаажуулсны дараа Улсын бүртгэлийн байгууллагад холбогдох бүртгэлийг хийлгэнэ.

Зургаа. Хяналт хариуцлага

6.1. Хороо энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

6.2. Хорооны шийдвэрийг үл зөвшөөрсөн этгээд шийдвэр гарснаас хойш Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасны дагуу Хорооны дэргэдэх Хяналтын зөвлөлд гомдол гаргаж болно.

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 1 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он:	Сар:	Өдөр:	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.)			
Улсын бүртгэлийн дугаар				
Регистрийн дугаар				
Хэсэг 1. Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны хүрээнд эрхлэх үйлчилгээний төрлийг сонгоно уу.				
<input type="checkbox"/> Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэх <input type="checkbox"/> Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх				
Хэсэг 2.1. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл				
Хуулийн этгээдийн хэлбэр	Хувьцаат компани <input type="checkbox"/>	Хязгаарлагдмал хариуцлагатай Компани <input type="checkbox"/>		
Хөрөнгө оруулалтын хэлбэр	Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/>	Гадаадын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/>		
Хаяг байршил	Аймаг/хот			
	Сум/дүүрэг			
	Баг/ хороо			
	Гудамж, байр			
	Гоот			
Холбоо барих утас				
Цахим хуудас				
Цахим хаяг				
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:				
Тайлбар: ДЭХ-давуу эрхийн хувьцаа ЭХ-энгийн хувьцаа				
Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш)	Хувьцааны төрөл	ХНХ-ийн хэмжээ	ХНХ-д эзлэх хувь (%)
	<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
	<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
	<input type="checkbox"/> ДЭХ	<input type="checkbox"/> ЭХ		
Эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл:				
Нэр:				
Хаяг:				
Утасны дугаар:				

И-мэйл хаяг:			
Өргөдөл гаргаж буй компанид эзэмшиж буй хувьцааны хувь, хэмжээ			
Хэсэг 2.2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл			
Үүсгэн байгуулагч этгээд нь аль нь болохыг сонгоно уу.	<input type="checkbox"/> Хуулийн этгээд <input type="checkbox"/> Иргэн		
1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол дараах мэдээллийг үнэн зөв бөглөнө үү.			
Хуулийн этгээдийн оноосон нэр	Монгол Англи		
Улсын бүртгэлийн дугаар			
Регистрийн дугаар			
Үүсгэн байгуулагдсан огноо	Он	Сар	Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хариуцлагатай компани		
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай		
Бизнесийн үйл ажиллагааны чиглэл			
Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө			
Хаяг байршил	Холбоо барих утас		
Цахим хуудас			
Цахим хаяг			
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх?	Тийм <input type="checkbox"/>	Үгүй <input type="checkbox"/>	
Та доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү.			
Оноосон нэр			
Регистрийн дугаар			
Компанийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Тусгай зөвшөөрөл хүсэгч компанитай ямар холбоотой болох	<input type="checkbox"/> толгой <input type="checkbox"/> хараат <input type="checkbox"/> охин <input type="checkbox"/> зэргэлдээ		
Байгуулагдсан огноо	Он	Сар	Өдөр
Үйл ажиллагааны төрөл			
Хаяг			
Холбоо барих утас			
Цахим хуудас			
Цахим хаяг			
2.3. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол доорх мэдээллийг бөглөнө үү.			
Овог			
Нэр			
Регистрийн дугаар			
Албан ёсны хаяг, байршил			

Эрхэлж ажил, тушаал	байгаа албан				
Ажлын хаяг					
Эзэмшсэн мэргэжил					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ					
Хэсэг 2.4. Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл					
Нийт ажилтан, албан хаагчдын тоо					
Албан тушаал	Овог	Нэр	РД	Цахим шуудан	Утасны дугаар
Гүйцэтгэх захирал					
Нягтлан бодогч					
Комплаенсын ажилтан					
Хэсэг 3. Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хувь хүний мэдээлэл					
Овог					
Нэр					
Хүйс		<input type="checkbox"/> Эрэгтэй		<input type="checkbox"/> Эмэгтэй	
Төрсөн огноо		Он	Сар	Өдөр	
Регистрийн дугаар					
Иргэншил					
Гэрийн хаяг байршил					
Эрхэлж байгаа ажил, албан тушаал					
Боловсрол		<input type="checkbox"/> Дээд	<input type="checkbox"/> Дунд	<input type="checkbox"/> Бүрэн дунд	
Эзэмшсэн мэргэжил					
Холбоо барих утасны дугаар		Гар утас:			
		Ажлын утас:			
		Гэрийн утас:			
И-мэйл хаяг					

Хэсэг 4. Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл	
Худалдаж авсан	<input type="checkbox"/>
Түрээслэсэн	<input type="checkbox"/>
Бусад	<input type="checkbox"/>
<i>Тэмдэглэл: үйл ажиллагаа явуулах ажлын байр нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх хаяг байршил, дүрэмд тусгагдсан хаяг байршилтай байна.</i>	
Хэсэг 5. Ашиглах техник, тоног төхөөрөмжийн мэдээлэл	
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, энэ журам болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно. Өргөдөл гаргасан:

_____	_____	_____
Үүсгэн байгуулагч	гарын үсэг	огноо
_____	_____	_____
Үүсгэн байгуулагч	гарын үсэг	огноо
_____	_____	_____
Үүсгэн байгуулагч	гарын үсэг	огноо
_____	_____	_____
Үүсгэн байгуулагч	гарын үсэг	огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 2 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл/хүсэлт гаргагчийн оноосон нэр						
Регистрийн дугаар						
Бүртгэлийн төрлийг сонгоно уу.						
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
А. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
Оноосон нэр/Овог нэр	РД	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсны дараах ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь(%)
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)						
Б. Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах						
Овог нэр	Харьяалал	РД	Хувьцааны тоо (ш)	ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 3 дугаар хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАР НЭЭХ,
ОНООСОН НЭРНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл/хүсэлт гаргагчийн оноосон нэр						
Регистрийн дугаар						
Бүртгэлийн төрлийг сонгоно уу.						
<input type="checkbox"/> Салбар, төлөөлөгчийн газар нээх <input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх						
Хэсэг 1. Салбар, төлөөлөгчийн газар нээх						
Нэгж байгуулах шийдвэр	Он		Сар		Өдөр	Дугаар
Нэгжийн хэлбэр	<input type="checkbox"/> Салбар		<input type="checkbox"/> Төлөөлөгчийн газар			
Хаяг байршил						
	Холбоо барих утас					
Цахим хуудас						
Цахим хаяг						
Салбар, төлөөлөгчийн газрын удирдах албан тушаалтны мэдээлэл						
Нэгжийн нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Албан тушаал	Овог, Нэр	РД	Цахим шуудан	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	
<i>Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг ажилтан бүрээр бичнэ.)</i>						
Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл						
Худалдаж авсан		<input type="checkbox"/>				
Түрээсэлсэн		<input type="checkbox"/>				
Бусад		<input type="checkbox"/>				
Ашиглах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл						
Техник тоног төхөөрөмжийн нэр төрөл						
Хэсэг 2. Оноосон нэр өөрчлөх						
Байгууллагын хуучин нэр				Регистрийн дугаар		
Байгууллагын шинэчилсэн нэр						

Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан	
--	--

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргасан:

Эрх бүхий албан тушаалтан

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, ХАЯГ, МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл/хүсэлт гаргагчийн нэр						
Регистрийн дугаар						
Бүртгэлийн төрлийг сонгоно уу.						
<input type="checkbox"/> Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт <input type="checkbox"/> Хаягийн өөрчлөлт <input type="checkbox"/> Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны өөрчлөлт						
Хэсэг 1. Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт						
Албан тушаал	Овог, нэр	Регистрийн дугаар	Цахим шуудан	Утасны дугаар		
<i>Тэмдэглэл (Өөрчлөлт оруулсан хүн тус бүрээр бичнэ)</i>						
Хэсэг 2. Хаягийн өөрчлөлт						
Хуучин хаяг						
Шинэ хаяг						
Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээ						
Хэсэг 3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтны өөрчлөлт						
Овог, нэр	Регистрийн дугаар	Цахим шуудан		Утасны дугаар		

Энэ журам болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно. Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр

гарын үсэг

огноо

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 5 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ (ХУУЛИЙН ЭТГЭЭД)

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх тухай компанийн төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ийн шийдвэр, хурлын тэмдэглэлийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
3	Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлсэн компанийн дүрэм. (дүрэмд Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлд заасныг тусгасан байна.)	
4	Хорооноос тогтоосон хувь нийлүүлсэн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт, гарал үүслийн тодорхойлолт	
5	Үнэт металл, үнэт чулууны эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгөд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, хуулга бусад баталгаа	
6	Компанийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө	
7	Компанийн үйл ажиллагаанд ашиглах ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, техник тоног төхөөрөмжийн талаарх танилцуулга, холбогдох баримт бичиг	
8	Эрх бүхий албан тушаалтан бүрийн энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт (Хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх захирал)	
9	Дотоод хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажилтны энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	

10	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналт болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр;	
11	20 сая төгрөг болон түүнээс дээш үнийн дүн бүхий гүйлгээ хийсэн харилцагчийн талаарх мэдээллийг хэрхэн зохицуулах болон хэрхэн хөтлөх талаар зохицуулсан дотоод үйл ажиллагааны журмын төсөл	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 6 дугаар хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮСЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ
(ХУВЬ ХҮН)**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэхүү журмын 1 дүгээр хавсралтаар баталсан маягтын дагуу үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл	
2	Иргэний үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
3	Энэхүү журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
4	Үйл ажиллагаа явуулах ажлын байр, зориулалтын тоног төхөөрөмжийн талаарх мэдээлэл (Үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар гэх мэт.)	
5	Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шаардлагыг хангасан байх	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 7 дугаар хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЭЦ, БҮРЭЛДЭХҮҮНИЙ ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 2 дугаар хавсралт дахь маягтын дагуу хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах талаарх өргөдөл	
2.	Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг	
3.	Бэлэглэлийн гэрээгээр хувьцаа шилжүүлж байгаа тохиолдолд Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн тухай хэлцэл, нотлох баримт бичиг	
4.	Шинээр орж буй хувьцаа эзэмшигч нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг болон энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
5.	Шинээр орж буй хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгөнд оруулах мөнгөн хөрөнгийн гарал үүсэл нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг	
6.	Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл	
7.	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахтай холбогдуулан хуулийн этгээдийн дүрэмд орох нэмэлт, өөрчлөлтийн эх хувь	
8.	Хувь нийлүүлсэн хөрөнгөнд ногдох мөнгөн хөрөнгийг өөрийн харилцагч банкны дансанд байршуулсан талаарх банкны тодорхойлолт, хуулга бусад баталгаа	
9.	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 8 дугаар хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ
ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН
ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Энэ журмын 4 дүгээр хавсралтын дагуу гаргасан өргөдөл	
2	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдийн шалгуурыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг, холбогдох шийдвэр, энэ журмын 12 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	
3	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг.	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 9 дүгээр хавсралт

**ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН
ГАЗАР НЭЭХЭД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу салбар нээх талаарх өргөдөл	
2.	Салбар, төлөөлөгчийн газар нээх эрх бүхий этгээдийн шийдвэр	
3.	Ажлын байр нь хуулийн этгээдийн өөрийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээсийн байр бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
4.	Үндсэн үйл ажиллагаанд ашиглах тоног төхөөрөмжийн талаарх жагсаалт	
5.	Салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журам	
6.	Нэмэлт, өөрчлөлт оруулсан дүрмийн төсөл	
7.	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 10 дугаар хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭР ӨӨРЧЛӨХӨД БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 3 дугаар хавсралт дахь маягтын дагуу оноосон нэр өөрчлөх талаарх өргөдөл	
2.	Оноосон нэр өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	
3.	Улсын бүртгэлийн байгууллагын хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	
4.	Өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь	
5.	Тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралт эх хувь	
6.	Оноосон нэр өөрчлөх болсон тайлбар	
7.	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 11 дүгээр хавсралт

ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ХАЯГ, БАЙРШИЛ ӨӨРЧЛӨХӨД БҮРТГҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 4 дүгээр хавсралт дахь маягтын дагуу хаяг байршил өөрчлөх өргөдөл	
2.	Хаяг, байршил өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	
3.	Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар	
4.	Өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь	
5.	Хорооноос шаардсан нэмэлт тодруулга, баримт бичиг	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 12 дугаар хавсралт

**МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АЖИЛТНЫ
ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1.	Энэ журмын 4 дүгээр хавсралт дахь маягтын дагуу гаргасан өргөдөл	
2.	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилсон эрх бүхий этгээдийн шийдвэр	
3.	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтан нь Тохиромжтой этгээдийн шаардлагыг хангасан эсэхийг нотлох баримт бичиг (Тохиромжтой этгээдийг тодорхойлох асуулгыг үнэн зөв, бүрэн гүйцэд бөглөсөн байх)	
4.	Энэ журмын 13 дугаар хавсралтын дагуу гаргасан тодорхойлолт	

Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 150 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам”-ын 13 дугаар хавсралт




ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ТОДОРХОЙЛОЛТ БОЛОН БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан талаарх мэдээлэл

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог	
Овог нэр	
Регистрийн дугаар	
Иргэний харьяалал	
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Ажлын хаяг	



2. Боловсрол /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

3. ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага болон бусад албан тушаалтны холбогдох этгээдийн байдал:

Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/.....//...../...../
 /Овог, нэр/ /гарын үсэг/ огноо